

## ТАНИЛЦУУЛГА

“Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл”-ийн тухай

### Төслийн зорилго, агуулга:

Төлбөрийн чадварт нийцсэн, байгаль орчинд ээлтэй 10,000 өрхийн орон сууцыг барих, гэр хорооллыг дахин төлөвлөх хөтөлбөрийг дэмжих, ногоон байгууламжийг бий болгох, ингэснээр агаар болон хөрсний бохирдлыг бууруулж, гэр хорооллын иргэдийн амьдрах орчныг сайжруулна.

### Төслийн байршил:

Төслийг Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн 1, 2 дугаар үе шаттай уялдуулан Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүдэд хэрэгжүүлэх урьдчилсан төлөвлөгөөтэй ажиллаж байна.

### Төслийн санхүүжилт:

Төслийг Уур амьсгалын ногоон сангийн 95 сая ам.долларын нэн хөнгөлөлттэй зээл, 50 сая ам.долларын буцалтгүй тусlamжийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ. Мөн, Азийн хөгжлийн банкны 80 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл болон Дэвшилтэт технологийн сангийн 3 сая ам.долларын буцалтгүй тусlamжийн эх үүсвэрээр тус тус санхүүжүүлэх юм.

Уур амьсгалын ногоон сангийн зээлийн хүү нь 0.25% бөгөөд зээлийн хугацаа нь 40 жил, үүнээс эхний 10 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгднө. Тус зээлийн эх үүсвэр нь нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй буюу хамгийн таатай нөхцөлтэй зээл болно.

### Төслийн хүрээнд хийгдэх ажлууд:

10,000 айлын орон сууцыг барих ба үүнээс 55% нь орлогод нийцсэн орон сууц, 15% нь түрээсийн орон сууц, 30% нь зах зээлийн үнэтэй орон сууц байна.

Нийт гэр хорооллын 100 га талбайг (i) холимог ашиглалт бүхий нийтийн эзэмшлийн зам, талбай болон байгууламж (ii) 60%-иас багагүй орлогод нийцсэн болон түрээсийн орон сууцанд амьдрах холимог орлоготой иргэд (iii) нөөцийн

хэмнэлттэй сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг<sup>1</sup> хамгийн дээд хэмжээгээр ашигласан эко хороолол болгон дахин хөгжүүлнэ.

Тухайлбал, Баянхшуу дэд төвийн баруун хэсгийн 5.1 га газрыг эко хороолол болгон хөгжүүлэх, ингэхдээ 495 өрхийн орон сууцыг таунхауз, нам давхрын барилга хэлбэрээр барьж байгуулах /4,170 м2 нарны панел, 4,450 м2 цэцэрлэгт хүрээлэн, 8,500 м2 нийтийн ногоон байгууламж, тоглоомын талбай, 2,130 м2 гараж, дэлгүүр, ЖДҮ-ийн барилга, байгууламжууд/, мөн Сэлбэ дэд төвийн зүүн хэсгийн 6.4 га газрыг эко хороолол болгон хөгжүүлэх, ингэхдээ 584 өрхийн орон сууцыг таунхауз, нам давхарын барилга хэлбэрээр барьж байгуулах /Орон сууцны барилгын 4,000 м2 нарны панел, 3,500 м2 цэцэрлэгт хүрээлэн, 13,500 м2 нийтийн цэцэрлэг, тоглоомын талбай, 584 м2 гараж, дэлгүүр, ЖДҮ-ийн барилга, байгууламжууд/ зэрэг ажлуудыг хийнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

---

<sup>1</sup> Эко бүрэлдэхүүнд (i) эрчим хүчиний хэмнэлтийн технологийг нэвтрүүлэх; (ii) photovoltaic нарны панел, нарны усан халаалтын системийг сууринуулах; (iii) газрын үр ашигтай төлөвлөлтийг нэвтрүүлэх ажлууд багтана.